



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/МНЭ

Ховд

Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын зүүн болон төвийн бүсийн зарим аймгуудад малын гоц халдварт олон улсын худалдааны хорио цээрт Шүлхий өвчний халдвар илэрсэн тул гоц халдварт өвчин дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд тус аймгийн нутаг дэвсгэрт Зүүн болон төвийн бүсийн аймгуудаас мал амьтан нэвтрүүлэх, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тархвар зүйн судалгаа хийх ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулж, сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/-т даалгасугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг чангатган Мал эмнэлгийн нэгдсэн системийг тогтмол хянаж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг аймаг сумдын Мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

2021/08/26